



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/373

Булган сум

Дотоод аудитын хорооны гишүүдийг шинэчлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн, нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 69.1, Засгийн газрын 2015 оны 12 сарын 14-ний өдрийн 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.13, 4.14 заалтууд болон Сангийн сайдын 2019 оны 02 сарын 20-ны өдрийн 29 дүгээр тушаалаар баталсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны төлөвлөгөөг батлах, төсвийн Ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайлан хэлэлцэн шийдвэрлэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий “Дотоод аудитын хороо”-д өөрчлөлт оруулсугай.

Дарга: Аймгийн Засаг дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Булган салбарын гишүүн

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
Иргэний төлөөлөл

Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга

Нарийн бичгийн дарга: Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах

байцаагч

2. Дотоод аудитын хорооны үйл ажиллагааг дүрмийн дагуу зохион байгуулж, тайланг хагас, бүтэн жилээр тайлагнахыг Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга (Б.Баттулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010483